

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ,
НИЙГМИЙН 2009 ОНЫ ЗОРИЛТ**

Улаанбаатар 2008 он

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2009 ОНЫ ЗОРИЛТ

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААР

№	Заалтын дугаар ¹	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
<i>Улаанбаатар хотын дэд салбаруудын хөгжлийг хангаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, нийслэл өөрийгөө тэтгэх эдийн засагтай, иргэд нь тогтвортой орлоготой байх эдийн засгийн орчин бүрдүүлнэ</i>			
1.	1.1.2	Нийслэлийг үйлдвэржүүлэх дэд хөтөлбөр боловсруулна	ХХБХ
2.	1.1.10	Нийслэлийн өмчийг эдийн засгийн идэвхитэй эргэлтэнд оруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хотын өмчийг өсгөх олон талт үйл ажиллагаа бүхий «Санхүүгийн корпораци»-ийг байгуулах бэлтгэл ажлыг үргэлжлүүлж, шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлнэ	НӨХГ
3.	2.2.2	20.0 мянган ажлын байр бий болгох, 15.0 мянган иргэнийг ажлын байранд зуучилна	НХНХГ
4.		Иргэдийн өөрсдийгөө ажлын байраар хангах үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана	
5.	2.2.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Нийслэлийн дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулна	
6.	2.2.4	Хөдөлмөрийн мэдээллийн сан бий болгоно	
7.		Хөдөлмөрийн нэгдсэн яармаг зохион байгуулна	
8.	1.1.6	Нийслэлд «Санхүүгийн түрээс»-ийн төв байгуулна	ЗАА /ХХААХҮЯам/
9.		Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих 2 төв байгуулна	
10.	1.1.7	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж эхэлнэ	ЗАА
11.	1.1.5, 3.5.2	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг банкны урт хугацааны, хүүгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахад зуучилна	
12.	2.2.4	Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул дүүргүүдэд үйлдвэрлэл технологийн парк байгуулах үйл ажиллагааг үргэлжлүүлнэ	НХНХГ
13.		Хөдөлмөрийн www.ubbirj.mn вэбсайт ажиллуулах, иргэд ажлын байрны мэдээллийг цахим хэлбэрээр /үүрэн холбооны тусламжтайгаар/ авах боломжоор хангана	

¹ Энэ нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг үзүүлсэн болно.

14.	2.2.4	Иргэд, оюутан залуучуудыг түр болон цагаар ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, ажил олгогч нартай хамтран ажиллана	НХБирж
15.		Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлнэ	
16.		Үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг нийслэлийн хэмжээнд бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ	
17.	1.1.11	Авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг цэгцлэх замаар Замын сан бүрдүүлэх механизмыг боловсронгуй болгох арга хэмжээ авна	НТГ
Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, гадаадын болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ			
18.		Аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг боловсруулж, мөрдүүлнэ	
19.	1.1.4	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулна	ЗАА
20.		Мэргэжилтэй ажилтан бэлтгэх <<Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв>-ийн төслийн саналыг доторуудад зориулж боловсруулна	
Хөрөнгө оруулалт, санхүү, төсвийн харилцаа, өмчийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно			
21.		Нийслэлийн төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн орлого нь үйлдвэрлэл үйлчилгээний өсөлт болон бизнесийн үйл ажиллагааны үр дүнгээс голлон хамаардаг болгох асуудлыг судалж боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авна: <ul style="list-style-type: none"> Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хуулиар хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгох, санхүү, төсвийн талаархи эрх хэмжээг нэмэгдүүлэх 	
22.	1.1.11	<ul style="list-style-type: none"> Нийслэлийн төсөвт нийслэлийн нутаг дэвсгэр дэхь аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээс хамаардаг орлогуудыг оруулдаг болгох 	СЭЗТСХ
23.		<ul style="list-style-type: none"> Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн НӨТ-ийн албан татварын орлогоос орон нутаг оршин суугчдын тоогоор хуваарилан олгодог эрх зүйн тогтолцоо бий болгох санал боловсруулж шийдвэрлүүлэх 	
24.		<ul style="list-style-type: none"> Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, Сангийн яам орон нутаг, салбарын төсвийн ерөнхийлөн захирагчдын хоорондын санхүү, төсвийн харилцааг төгөлдөршүүлэх 	
25.	1.1.10	Дүүргүүдийн эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх зорилгоор өмч шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалт хийнэ	ХЗХ НӨХГ
Нийслэлийн хүн амын хүнсний нөөц, хангамж ба үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлнэ			
26.		Нийслэлийн хүнс, хөдөө, аж ахуйн талаар баримтлах бодлого, «Хүртээмжтэй хүнс» хөтөлбөр боловсруулна	ХХБХ
27.	1.2.1	Нийслэлийн дүүрэг бүрт халуун талхны цех байгуулахад хөрөнгө, санхүү, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана	ЗАА /ХХААХҮЯам/
28.	1.2.2	«Махны нөөцийн сан» байгуулна	ХХБХ, ҮҮХ /ХХААХҮЯам/
29.		Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан 7.0 мянган тонн мах бэлтгэж, нөөцөлнө	ЗАА

30.	1.2.3	Махны худалдааны төрөлжсөн биржийг Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-уул дүүрэгт, «Малын бирж»-ийг шинэ суурьшлын бүсэд байгуулах ажлыг эхлүүлнэ	ЗАА, Дүүргүүд /ХХААХҮЯам/
31.	1.2.6	Ариутгасан сүү борлуулах загвар 3 цэг, БЗД, СБД-т сүүний хөргөлтийн 2 төв байгуулна	НХХААГ /ХХААХҮЯ/ ХХААГ /ХХААХҮЯ/
32.	1.2.7	«Хүүхэд бүрт нэг аяга сүү» аяныг хэрэгжүүлж эхэлнэ	НХХААГ /ХХААХҮЯ/
33.	1.2.6	Сүүний чиглэлийн үнээний 5 загвар аж ахуйн нэгж бий болгоно	НХХААГ
34.	1.2.4	Шинэ суурьшлын бүсэд 5000 тн багтаамжтай механикжсан зоорь байгуулна	НХХААГ
35.		Нийслэлийн өрхийн аж ахуйг дэмжих чиглэлээр 190 ширхэг нийлэг хүлэмжийг иргэдэд нийлүүлнэ	НХХААГ /ХХААХҮЯам/
36.		Хувийн хэвшлийн хөрөнгөөр Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт хүлэмжийн аж ахуй байгуулна	
37.	1.2.8	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 1512.9 мянган мал, амьтныг хамруулна	НМЭГ
38.	1.2.9	Мал, амьтны хашаа байр, үйлдвэрлэл, үйлчилгээний газар, хүнс, түүхий эдийн зах, худалдааны төвд нийтдээ 820.0 мянган м ² талбайд ариутгал, халдваргүйтгэл хийнэ	

ХОЁР. НИЙГМИЙН АМЬЖИРГААНЫ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ

№	Заалтын дугаар	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
Алслагдсан дүүрэг хороодын хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийн үр дүнтэй үйлчилгээг яаралтай тусламж болон лавлагаа тогтолцоотой уялдуулан хүргэнэ. /2008-2010 он хүртэл/			
1.	2.3.7	Түргэн тусламжийн үйлчилгээний удирдамж боловсруулж, батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ	НЭМГ
2.		Түргэн тусламжийн үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, зориулалтын автомашины тоог нэмэгдүүлж, засвар үйлчилгээг тогтмолжуулна	
3.		Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг ойртуулах, дуудлага хүлээгдэлтийг багасгах зорилгоор түргэн тусламжийн салбар нэгжүүдийг зохион байгуулж байр, техник тоног төхөөрөмжөөр хангана	
Нийслэлийн эрүүл мэндийн салбарын бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, техник технологи, программын шинэчлэл хийнэ. /2008-2010 он/			
4.	2.3.3	Нийслэлийн эрүүл мэндийн салбарын хооронд өвчтөний мэдээлэл авах, лавлагаат тусламж үйлчилгээний сүлжээг бий болгоно. НЭМГ – харьяа байгууллагууд /29\	НЭМГ ХЗХ
5.		Электрон шуудан, утсаар үзлэг шинжилгээний захиалга авах ажлыг «Энэрэл» эмнэлэгт туршиж эхлүүлнэ	НЭМГ
Орчин үеийн шаардлагад нийцсэн технологийн өндөр түвшний оношлогоо, эмчилгээ болон лабораторийн багаж, тоног төхөөрөмжөөр нийслэлийн эмнэлгүүдийг хангах ажлыг дэс дараатай зохион байгуулж тусламж үйлчилгээг чанартай хүргэнэ.			
6.	2.3.4	Нийслэлийн эрүүл мэндийн салбарын эмнэлэг эрүүл мэндийн байгууллагуудыг ариутгалын болон сэхээн амьдруулахын аппарат төхөөрөмж, дүрс оношлогооны зарим тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хийнэ /тусгай төлөвлөгөөгөөр/	НЭМГ
7.		Дүүргийн ЭМН-үүдийн наркологийн кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлж техник тоног төхөөрөмжөөр хангана	
8.		Найман дүүргийг бүсчилэн хорт хавдар илрүүлэх маммографийн аппаратаар, зарим дүүргүүдийг нөхөн сэргээх эмчилгээний аппаратаар хангана	
9.		ШЭНЭСТөвд дэлхийн шинжлэх ухааны ололт болсон «Имплант»-ын үйлчилгээг нэвтрүүлнэ	
10.		Сургалтын иж бүрэн кабинетыг Хонхор тосгоны эмнэлэгт байгуулна	
11.	Хүүхдийн клиник сувилал №4-д гал тогооны болон усан бассейны сорох систем суурилуулна		
Нийслэлийн эрүүл мэндийн салбарын чадавхийг бэхжүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.			
12.	2.3.3	НЭМГ-ын чадавхид шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээг авах асуудлыг дахин холбогдох газруудад тавина	НЭМГ
13.		Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын чанарын менежер, халдвар судлаач, сувилахуйн менежерүүдэд зориулсан «Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчлүүлэгчид чиглэсэн үр дүнтэй үйлчилгээ» /COPE/ «Дэмжлэгт удирдлага», «Чанарын удирдлага», «Эмнэлзүйн хөтөч боловсруулах», «Чанарын шалгуур үзүүлэлт» зэрэг сургалтын багц хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ	

14.		Нийслэлийн эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийн төлөвлөлт төсөвлөлт хийх чадварыг сайжруулах хөтөлбөрт хамруулах, сургагч багш бэлтгэнэ	
15.	2.3.3	«Нийслэлийн хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний чанарын үнэлгээний зарим асуудалд» судалгаа хийж, хүлээлгэн өгөх, судалгаагаар гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангуулна	НЭМГ
16.		«Архаг өвчний үеийн тусламж үйлчилгээний менежментийг сайжруулах» цуврал сургалтыг бүх дүүргийн эмч мэргэжилтнүүдэд хийж үр дүнг тооцно	
Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үйл ажиллагааг удирдан зохицуулсанаар хянан тандах тогтолцоог бүрдүүлж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгоно.			
17.	2.3.1	«Нийслэлийн Эрүүл-Загвар сургууль» хөтөлбөрийн хүрээнд Чингэлтэй, Баянзүрх дүүргийн 23, 33 дугаар сургуулиудад эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн цахим сантай болгоно	НЭМГ
18.		«Таны эрүүл мэнд-Таны гарт» сэдэвт халдварт бус өвчнөөс сэргийлэх иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зайны сургалтын цахим ном \И-СД\ бүтээж, нийтийн хүртээл болгоно	
19.	2.3.6	ХБӨ-ний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд 3-4 дүүргийн үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийж, дүгнэлт өгч, зөвлөмж гаргана	НХХ
20.		Нийслэл УБ хотын хэмжээнд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх эхний шатны үйл ажиллагааг эхлүүлнэ	НЭМГ
21.		Хүн амд зохистой хооллолт, идэвхитэй хөдөлгөөн болон архи тамхигүй аж төрөх талаар эрүүл мэндийн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөө хийж, хэрэгжүүлнэ	
22.	2.3.1	Нийслэлийн ресторан зоогийн газруудад «Тамхиар үйлчилгээ үзүүлэхгүй байх» хөдөлгөөнийг өрнүүлж үр дүнг тооцно	
23.		Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх олон талт ажлыг зохиохоос гадна «Таны төлөө бидний сэтгэл» эрүүл мэндийн улирал тутмын сонинг «ТТБС» төрийн бус байгууллагатай хамтран шинээр гаргаж иргэдэд хүргэнэ	
24.	2.3.10	«Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тогтолцоог сайжруулахад эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь» төслийн хүрээнд Чингэлтэй дүүргийн сайн дурынхантай ажиллаж буй туршлагыг загвар болгон хэрэгжүүлнэ	НЭМГ
25.	2.3.6	«Нийслэлийн агаарын бохирдол амьсгалын замын өвчлөлд нөлөөлж буй байдал», «Нийслэлийн хүн амын унд ахуйн усан хангамж, түүний аюулгүй байдал» сэдэвт судалгааны ажлуудыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран 2008 онд хийсэн үр дүнгийн дагуу агаарын бохирдлоос үүсэх өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, унд ахуйн усан хангамжийг сайжруулах зэрэг зөвлөмж боловсруулж хүн амын дунд орчны эрүүл мэндтэй холбоотой халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулна	
Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар байгууллага, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлснээр эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулна.			
26.	2.3.7	5 хүртэлх насны хүүхдийг хоол тэжээлийн дутлын байдалд олон улсын байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тандалт хийж, зөвлөмжийг хэрэгжүүлнэ	НХХ НЭМГ
27.		Холбогдох байгууллагуудтай хамтран нийслэлд гаж хөгжилтэй төрж буй хүүхдийн асуудлаар судалгааг хийнэ	

28.		Ургийн гаж хөгжлийг жирэмсний эхний саруудад эхийн хэвлийд оношлох арга, технологийг шинээр үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ба эмч мэргэжилтнийг бэлтгэх ажлыг зохион байгуулна	
29.		«Ургийн гаж хөгжлийн оношлогоо» сэдэвт гарын авлага номыг бүтээж, үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлнэ	
30.	2.3.7	Монгол улсын мянганы хөгжлийн зорилтын нэг болох эх хүүхдийн эндэгдлийг бууруулах асуудлаар салбарын хэмжээнд олон талт ажлыг өрнүүлэхээс гадна «Эх хүүхдэд ээлтэй тэргүүний дүүрэг» шалгаруулах болзол гарган, шалгаруулах ажлыг НЗДТГ-тай хамтран хийнэ	НХХ НЭМГ
31.		Оношлогооны хурдавчилсан оношлуурыг хэрэглэх замаар БЗДХ-ын тусламж үйлчилгээг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй уялдуулж БЗДХ-ын халдварын эрсдэлийг бууруулна	
32.		3-р амаржих газрын цэвэрлэгээ үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийг хийдэг туршлагыг үндэслэн удирдамж боловсруулж, батлуулан мөрдлөг болгох ба бусдад нэвтрүүлнэ	
Хүн ам, ялангуяа эмээг болон эрсдэлт бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх ажлыг төлөвлөж зохион байгуулна.			
33.		ХДХВ/ДОХ/бэлгийн замаар дамжих халдвартай тэмцэх сэргийлэх ажлын хүрээнд оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх 1 цэгийн үйлчилгээтэй «Сэтгэл амар» төвийг Чингэлтэй дүүрэгт шинээр байгуулж багаж, тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг эхлүүлнэ	
34.	2.3.8	Сүрьеэ өвчний илрүүлэлт, эдгэрэлтийг сайжруулах зорилгоор өрхийн эмнэлгүүдэд сүрьеэг эмчлэх, оношлох, үйл ажиллагааг цогцоор нь Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт нэвтрүүлж эхлэх ажлыг зохион байгуулна	НЭМГ
35.		Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан В, С гепатитын халдварт өртөх эрсдэл өндөртэй иргэдийг дархлаажуулалтанд хамруулах тоог нэмэгдүүлнэ	
Сувилахуйн тусламж үйлчилгээний удирдлага зохион байгуулалтыг сайжруулж нийгмийн хэрэгцээнд тулгуурласан үр дүнтэй хэлбэрээр хөгжүүлнэ.			
36.		Эрүүл мэндийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний төлөөллийг оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ	
37.	2.3.9	Нийслэлийн дүүргүүдэд сувилахуйн кабинетуудыг байгуулж, тоног төхөөрөмж, хэрэгслэлээр хангана	НЭМГ НХХ
38.		Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын тулд «Зонхилон тохиолддог эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламжийн удирдамж» боловсруулж, мөрдлөг болгон ажиллуулна	
Эрүүл мэндийн анхан шатны тусламжинд суурилсан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэхэд орон нутгийн засаг захиргаа болон өрхийн эмнэлгүүдийн уялдаа холбоог сайжруулна.			
39.	2.3.11	Гэдэсний халдварт өвчний тархалтанд нөлөөлж буй хүчин зүйлийг арилгах ажлын хүрээнд гэр хороололд гар угаах гоожуурт угаагуургүй байгаа айл өрхийг гоожуурт угаагууртай болгох ажлыг зохион байгуулах шийдвэрийг гаргуулна	НЭМГ НМТГ
40.	2.3.10	Өрхийн эмнэлгийн багийн ахлагч нарыг хамруулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өрхийн эмнэлэгт удирдлага, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох, суралцагч байгууллага, эмч ажилчдын идэвхийг өрнүүлэх, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна	НЭМГ
Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, хариу арга хэмжээ авах салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, харуулдан тандалтын тогтолцоог бий болгоно.			

41.	2.3.11	Нийслэлд халдварт өвчнөөс эрт сэргийлэх хариу арга хэмжээ авах хяналт тандалтын мэргэжлийн алба байгуулна	НЭМГ
42.	2.3.4	Эмнэлгийн тусламж үйлчилгээний анхан шатны байгууллага өрхийн эмнэлгийн түвшинд ХДХВ/ДОХ/БЗДХ-ийг илрүүлэх, эмчлэх, үйлчилгээг хийх чадавхийг сайжруулах, оношлогоонд шаардлагатай тоног төхөөрөмж, чанартай эм, урвалж, оношлуураар тасралтгүй хангана	
43.	2.3.11	Байгалийн голомтод халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, мэдээлэл, сургалт сурталчилгааг өргөнөөр зохион байгуулах, тандалтыг тогтмол хийж, эрт илрүүлэх арга хэмжээ авч ажиллана	
44.	2.3.4	Баянгол, Сүхбаатар дүүргийн ЭМН-үүд бактериологийн лаборатори байгуулж үйл ажиллагаанд оруулна	
Эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулан, үндэсний эмийн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.			
45.	2.3.12	Нийслэлийн хэмжээнд өргөн олныг хамарсан гамшиг осол, өвчлөл гарсан үед хэрэглэх зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх шийдвэрийг гаргуулна	НЭМГ
46.		Эмийн тухай бодит мэдээллийг олон нийтэд хүргэх, нийслэлийн хүн амд эмийн зохистой хэрэглээний мэдлэг олгох, түүнийг төлөвшүүлэх арга хэмжээг дэс дараатай зохион байгуулна	
Нийслэлийн эмнэлэг эрүүл мэндийн байгууллагуудыг зориулалтын барилга байгууламжтай болгох ажлыг эхлүүлнэ.			
47.	2.3.4	Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийн өргөтгөл /СБД/	НЭМГ
48.		Эрүүл мэндийн нэгдлийн байр 2007-2010 он, 3,9 тэрбум, үүнээс 2009 онд 960 сая төгрөг /БГД/	
49.		УБ хотын 4-р амаржих газрын байрыг шинээр барих, 2009-2010 он, 6,3 тэрбум, үүнээс 2009 онд 270 сая төгрөг	
50.		БЗД-ийн нэгдсэн эмнэлэгт өвчтөний тохилог орчинг бүрдүүлэхийн тулд хөдөлгөөнд таазны хошиг суурилуулна	
51.		Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын барилгын их засвар 1 тэрбум төгрөг \тусгай төлөвлөгөөгөөр\	
СӨБ болон бага, дунд боловсролын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэн, ЕБС-уудыг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, албан бус сургалтаар хүүхэд, өсвөр үеийг хөгжүүлнэ.			
52.	2.4.1	«Боловсрол» дэд хөтөлбөр боловсруулж, батлуулж мөрдөнө	НБГ
53.	2.4.9	Алслагдсан гэр хороололд цэцэрлэг шинээр барих ажлыг үргэлжлүүлж, хүчин чадал багатай цэцэрлэгийг өргөтгөнө	НБГ Дүүүргүүд
54.	2.4.17	Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг мэргэжлийн үүднээс дэмжиж ажиллана	НХХ
55.	2.6.1	Хүүхдийн чийрэгжилтийн танхимыг цэцэрлэг бүрт байгуулах ажлыг эхлүүлнэ	НБГ, НБТСХ

56.	2.4.3	Бага дунд боловсролын тухай хуульд заагдсан хамран сургах тойргийг дүүрэг бүрт тогтоох тухай заалтыг хэрэгжүүлснээр сургуульд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлнэ	НБГ
57.	2.4.7	Сургуулийн суудлын тоо, цэцэрлэгүүдийн орны тоог нэмэгдүүлэх, сургалтын орчин нөхцлийг сайжруулна	
58.	2.4.3	Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой буюу 3-аас дээш хүүхэд нь ЕБС-д суралцдаг өрхийн хүүхдийн сурах боломжинд нь дэмжлэг үзүүлнэ	НХХ
59.	2.4.12	«Үдийн цай» хөтөлбөрийг «Үдийн хоол» болгон өргөжүүлэх, суралцагчдын хоолны эрүүл ахуй сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилнэ	НБГ
60.	2.4.10	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг нийгэмшүүлж, ердийн сургалттай сургуульд суралцах боломжоор хангахад чиглэсэн түшиц сургуулийг зарим дүүрэгт бий болгох асуудлыг судлана	НХХ
61.	2.4.7	Шаардлагатай сургууль, цэцэрлэгийн гадаа бие засах газар болон ариун цэврийн өрөөг стандартын шаардлагад нийцүүлнэ	НБГ Дүүргүүд
62.	2.4.19	Боловсролын нийгмийн ажилтныг мэргэшүүлэх дадлагажуулах, хүүхэд, өсвөр үеийнхэнтэй ажиллах, сургуулиас гадуурх сургалтын шинэлэг арга зүйд суралцуулах зорилгоор ХБНГУ-ын туршлагыг судлан орон нутагт түгээх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна	НБГ, НХЗГ
Багш удирдах ажилтаны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх оновчтой тогтолцоог бий болгоно.			
63.	2.4.13.	Сургууль бүрд «Багшийн хөгжлийн төв»-ийг байгуулж, шаардлагатай техник хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмжөөр хангана	НБГ
64.	2.4.16.	Нийслэлийн сургагч багшийн мэргэжлийн хослол бий болгож хичээл бүрээр сургагч багшийн баг бүрдүүлнэ	
«Биеийн тамир, спортын тухай» Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, биеийн тамир, спортын барилга, байгууламж, материаллаг баазыг бэхжүүлнэ.			
65.	2.6.5	Нийслэлийн спорт цогцолборын барилгыг эхлүүлнэ	НБХБТГ, НБТСХ
66.		Олимпын залгамж халааг бэлтгэх, өсвөрийн тамирчдын авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор спортын төрөлжсөн дунд сургууль байгуулах ажлыг дэмжиж, зохион байгуулна	НХХ
67.	2.6.1	Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбайг нийслэлийн орон сууцны дунд 1-2-ыг барьж байгуулна	НХХ, НБТСХ
68.	2.6.2	Биеийн тамир, спортын үйл ажиллагаа явуулахад шаардагдах спортын хэрэглэл, материал, тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээг сайжруулна	НБТСХ
Нийслэлийн хүн амын дунд зохион байгуулах биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулна.			
69.	2.6.6	Нийслэлийн өсвөрийн баг тамирчдыг Сингапурт болох Азийн Хүүхдийн спортын их наадамд оролцуулах ажлыг зохион байгуулна	НБТСХ
70.	2.6.2	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЕБС-иудад сургалт, судалгааны танхим байгуулна	НБТСХ НХХ
71.	2.6.1	Төр захиргааны байгууллагын ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх биеийн тамир чийрэгжүүлэлтийн танхим байгуулна	
72.	2.6.3	Оюутны спортын II их наадмыг нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулна	
73.		Нийслэлийн хэмжээнд нийтийг хамарсан спорт, биеийн тамирын 20-иос доошгүй арга хэмжээг зохион байгуулна	

Биеийн тамир, спортын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.			
74.	2.6.6	Ах дүү хотуудын биеийн тамир, спортын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, баг тамирчид төлөөлөгчдөө харилцан солилцож туршлага судлуулна	НБТСХ
75.		Тив, дэлхий, бус, олон улсын чанартай спортын томоохон уралдаан тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана	
Соёлын салбарт Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрүүдийг нийслэлд хэрэгжүүлнэ.			
76.	2.7.1.	«Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах сэргээн засварлах», «Соёлын өвийг тоон системд оруулан хадгалах» хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлнэ	НСУГ НХХ
77.		«Морин хуур, уртын дуу», «Монгол хөөмэй» хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	
Нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүрээг өргөтгөн, хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
78.	2.7.2.	Соёл урлагийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	НСУГ НХХ
79.	2.7.11	УБ хотын Төв номын сангийн харъяа салбар номын сангууд, алслагдсан дүүргийн номын сангуудыг, интернэт сүлжээнд холбох бэлтгэл ажлыг хангана	
80.	2.7.1	УБ хотын Түүх шинэчлэн байгуулалтын музейн барилгын өргөтгөлийн зураг, төсвийг хийлгэнэ	
81.		Нийслэлийн иргэдийн ахуйн болон харилцаа, хэрэглээний соёлыг дээшлүүлэх «Соёлтой иргэн - Соёлтой хот» бүтээлч ажлыг өрнүүлнэ	
82.		Соёлын үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн үйл ажиллагааг дэмжиж, соёл урлагийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулна	
83.	2.7.6	Соёлын төв өргөө, Улаанбаатар чуулгын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь сайжруулах санал боловсруулан НИТХ-аар шийдвэрлүүлнэ	
84.	2.7.1	Хан-Уул дүүргийн Соёлын төвийн «Худалдах, худалдан авах» гэрээг цуцалсантай холбогдуулан хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлнэ	
Соёл урлагийн гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлнэ.			
85.	2.7.12	Соёл урлагийн байгууллагын ажилтнуудыг гадаадын харилцаат хотуудад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна	НСУГ ГХХАХ
86.		ОХУ-ын Москва, Буриад улсын Улаан-Үд хот, БНСУ-ын Сөүл, Намьянжү хотуудын соёл урлагийн газартай харилцаа хамтын ажиллагаа тогтооно	
Соёл урлагийн олон талт үйл ажиллагааг жигд чанартай зохион байгуулна.			
87.	2.7.1	«Уулс туульсийн Улаанбаатар» хөгжимт жүжиг, шинэ уран бүтээл хийнэ	НСУГ УБ чуулга
88.		Монгол Улсын хөдөлмөрийн баатар, АЖ, ТШ хөгжмийн зохиолч Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах уламжлалт уралдааныг зохион байгуулна	НСУГ НБГ
89.		«Монгол Улсын төрийн дуулалыг зөв дуулж сурцагая» хөдөлгөөн өрнүүлэх, «Нийслэлийн тухай дууг хэн сайн дуулах вэ» уралдаан, «Миний нийслэл» яруу найргийн наадам, «Нийслэлийн түүх зураачдын нүдээр» зургийн цомог хийх зэрэг ажлуудыг нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 370 жилийн ойд зориулан зохион байгуулна	НСУГ

Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийн 3-р шатны зорилтыг талуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлнэ.			
90.	2.5.1	«Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах» нийслэлийн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ	НХЗГ НХХ
91.		Нийслэлийн хүүхдийн аж байдлын суурь судалгааг явуулж, хүүхдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг байгуулна	
92.		Хүүхэд хамгааллын үйлчилгээний яаралтай тусламжийн тогтолцоог бий болгож, зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ	НХЗГ Дүүргүүд
93.		Хүүхдийн аж байдлыг сайжруулах асуудлаар нийслэлийн удирдлагуудын зөвлөгөөнийг зохион байгуулна	НХЗГ, НХХ, НСГ
94.		Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд «Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээний стандарт»-ыг хэрэгжүүлэхэд хяналт тавина	НХЗГ НМХГ
95.		Хараа хяналтгүй хүүхдийг харьяалалтай болгох ажлыг зохион байгуулна	НХЗГ, НЦГ
96.		Хүүхдийг дотоодод үрчлэх ажиллагааг хүүхдийн эрхийн олон улсын баримт бичгийн зарчим, стандартад нийцүүлэх, хяналт тавьж ажиллана	НХЗГ, НЦГ, НХХ
97.	Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, нийгмийн түншлэлийг бий болгоно	ХЗХ, Дүүргүүд НХЗГ, ЗЦГ	
«Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах» нийслэлийн дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэгч хүүхдийг нийгэмшүүлэх, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.			
98.	2.5.2	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад нийслэлийн төр захиргааны бүх шатны байгууллагуудын оролцоо, чадавхийг нэмэгдүүлэх зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно.	НХЗГ НХХ Дүүргүүд
99.	2.5.3	Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг нийгэмшүүлэх, боловсролын үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөрөөс хөндийрүүлнэ	
100.	2.5.2	Хүүхдийг хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа сургалтуудыг олон нийт болон мэргэжлийн бүлгүүдэд зохион байгуулна	
Залуучуудын сүрч боловсрох, амьжиргааны чадавхиа дээшлүүлэх нөхцөл бололцоог сайжруулна.			
101.	2.5.6	ХБНГУ-ын Сургуулиас гадуурх сургалтын байгууллагуудын холбоотой хамтран хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудлаар нийгмийн ажилтныг мэргэшүүлэх ээлжит симпозиумыг зохион байгуулах, хөгжсөн орны туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг орон нутгийн болон холбогдох байгууллагуудтай хамтарч зохион байгуулна	НХЗГ ГХХАХ НХХ
102.		Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 16-35 насны залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд үнэ төлбөргүй хамруулна	НХЗГ НХНХГ
103.	2.5.6	Өсвөр үе залуучуудыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сурталчилгаа, сургалтуудыг зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавина	НХЗГ
104.		Нийслэлийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна	
Гэр бүлд чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээг цогц байдлаар хүргэх үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлнэ.			
105.	2.5.5	НҮБ-ын Хүүхдийн сан, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо НЗД-тай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу нийгмийн цогц суурь үйлчилгээг өрх бүрт хүргэх хөтөлбөрийг Багануур, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлж орон нутгийн бодлогыг тусгуулж үр нөлөөг тооцно	НХЗГ
106.		Дүүргүүдэд болон Хүүхэд залуучуудын газрын дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа «Гэр бүлд зөвлөгөө өгөх төв»-үүдийн үйл ажиллагааг бэхжүүлж, шинээр 4 дүүрэгт «Гэр бүлийн төв»-үүдийг байгуулна	

107.	2.5.5	«Жендерийн тэгш байдлыг хангах» үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхэд залуучууд, залуу гэр бүлд чиглэсэн гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулна	НХЗГ НХХ
Гэр бүлийн харилцааг боловсронгуй болгох, гэр бүл дэх хүчирхийллийг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.			
108.	2.5.5	«Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх» үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод болон тэдний гэр бүлд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх тогтолцоог бий болгон хөгжүүлнэ	НХЗГ НХХ
Хүүхэд өсвөр үеийнхний нийгмийн оролцоог дэмжин, нийгэм хамт олонд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлнэ.			
109.	2.5.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний сурах, хөгжих боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	НХЗГ
110.	2.5.7	«Нийслэлийн хүүхдийн холбоо», дүүргүүдийн хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудыг чадваржуулж, үйл ажиллагааг тогтмолжуулахад дэмжлэг үзүүлж ажиллана	НХЗГ, НБГ
111.	2.5.1	Нийслэлийн ногоон бүсийн зуслангуудыг стандартын дагуу ажиллуулж, хяналт тавина	
112.		Хүүхдийг богино хугацаанд нийгэмшүүлэн төлөвшүүлэх арга зүйг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна	
113.	2.5.7	Шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцох боломжийг нэмэгдүүлж хамтарч ажиллана	
Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д ажиллагсад, Монгол улсын иргэн болон гадаадын иргэн, харъяалалгүй хүмүүсийг нийгмийн даатгалд хамруулна.			
114.	2.2.7	Сангийн орлого бүрдүүлэлт, жигд ажиллагааны үзүүлэлтийг салбар нэгжүүдийн менежерийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлнэ	ННДГ
115.		Нийгмийн даатгалын хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийг иргэдэд сурталчилан таниулах ажлыг тодорхой график төлөвлөгөөний дагуу зохион байгуулна	
Иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч, тэтгэврийн дундаж хэмжээг 30,0 –оос доошгүй хувиар нэмэгдүүлэн 221,0 мянган иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгоно.			
116.	2.2.7	Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дагуу тэтгэврийн нэмэгдэл тооцох ажлыг шуурхай зохион байгуулан тэтгэврийг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ	ННДГ
117.		Тэтгэврийг цахим тооцооны хэрэгсэл ашиглан олгох ажлыг эрчимжүүлнэ	
Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар даатгуулагч иргэдийн сэтгэлгээнд болон хандлагад гарч буй өөрчлөлтийг тандан судлах чиглэлээр социологийн судалгаа явуулна.			
118.	2.2.7	Нийслэлийн статистикийн газартай хамтран үр дүнг программ хангамжаар гаргах ажлыг зохион байгуулна	ННДГ
119.		Судалгаанд шимтгэл төлөгч, тэтгэвэр авагчдыг өргөн хамруулна	
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг үндэслэн өртөг ойролцоо оношын бүлгээр санхүүжилт хийх ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.			
120.	2.2.7	Харилцагч эмнэлэг нэг бүртэй хийсэн гэрээний дагуу санхүүжилтийг олгоно	ННДГ
121.		Шинэ зарчмаар олгосон багцын санхүүжилтийг тайлан тэнцэлд гүйцэтгэлээр тусгах ажлыг программ хангамжинд тусган хэрэгжүүлнэ	

ГУРАВ. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААР

№	Заалтын дугаар	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
Газар ашиглалт, нутагшилт сууршлын зохистой бодлогыг хэрэгжүүлж хот төлөвлөлтөнд «нягт сууршилтай хот»-ын загварыг баримтлан алслагдсан суурингуудын хөгжлийг тэтгэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүн ам тухайн нутаг дэвсгэртээ тогтвор сууршилтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.			
1.	3.1.1	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлын үр дүнг хүлээн авч хуульчлах, мөн түүнийг чанадлан мөрдүүлэх зохистой бүтцийг бий болгож хэрэгжилтийг хангана	ХХБХ ТУН
		»Хотыг дахин хөгжүүлэх тухай», «Хотын ногоон байгууламжийн тухай», «Газрыг дахин зохион байгуулах тухай», «Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай» зэрэг хуулийн төслийг боловсруулан батлуулна	ТЗУХ, ХХБХ, ХЗХ
2.	3.1.2	«Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө»-г тодотгох хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж хэрэгжүүлнэ	НГА
3.	3.1.3	Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, хот төлөвлөлт, барилгажилт, газар олголттой холбогдсон үйл ажиллагаанд нээлттэй, шудрага зарчмаар шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлж, газрын маргааныг таслан зогсооно. Үүний тулд:	ХХБХ, БХБТГ, НГА
4.		<ul style="list-style-type: none"> Хот байгуулалт, газар зохион байгуулалтын Мэргэжлийн комиссын дүрэм»-ийг шинэчлэн батлуулна 	
5.		<ul style="list-style-type: none"> Орон сууцны хорооллын батлагдсан ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй барилга, байгууламжийг барих асуудлыг таслан зогсооно 	
6.		<ul style="list-style-type: none"> Барилга, байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын бүрэлдэхүүнийг өөрчлөх, журмыг шинэчлэнэ Газрын бирж байгуулах саналыг НИТХ-д өргөн барина 	
Хотын хөгжлийн бодлогын хэрэгжилттэй хөрөнгө оруулалтын бодлогыг нягт үялдуулан хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлнэ.			
7.	3.1.4	2008 оны улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн орон сууцны хороолол, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний зураг төслийн санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж, хэрэгжүүлэгч байгууллагад хүлээлгэн өгч, хэрэгжилтийг хангуулна	СЭЗТСХ, БХБТГ
8.		Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийн I үе шатанд /2008-2011/ хэрэгжих Орон сууцны 7, 14 дүгээр хороолол, Монголын үндэсний Радио телевизийн хэрэг эрхлэх газрын орчны орон сууцны хорооллын инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, зам талбай, үерийн далан суваг барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ	СЭЗТСХ
9.		Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдах Энгельсийн гүүрийн барилгын дотоодын эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулна	
10.		БНСУ-ын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр баригдах «Улаанбаатар хотын зам тээврийн оновчтой систем» төсөлд болон АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх «Хот байгуулалтын салбарын МОН 2301 төсөл»-ийн дэд төсөлд шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэн хэрэгжүүлнэ	
11.		Улс, нийслэлийн төсвийн урсгал орлогын хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй зам, замын байгууламжуудад шаардагдах нэмэлт санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулна	

12.		Гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн уялдааг хангах зохистой бүтцийг бүрдүүлж, хэрэгжилтийг эрчимжүүлнэ	ГХХАХ
13.		Улсын төсвийн 2009 оны төсөлд тусгагдсан «орон сууцны цахилгаан шат, инженерийн шугам сүлжээ, эх үүсвэрийн өргөтгөл шинэчлэлт»-ийн ажлыг оны эхнээс шуурхай зохион байгуулж, ажлын уялдааг ханган хугацаанд нь хэрэгжүүлнэ	БХБТГ
14.	3.1.4	СХД-ийн 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, СБД-ийн 18-р хорооны 100 ортой цэцэрлэгийн барилга, БЗД-ийн 16-р хорооны 21-р цэцэрлэгийн өргөтгөл, Багануур, Налайх дүүргийн 75 хүүхдийн цэцэрлэг, БЗД-ийн 12-р хорооны 100 ортой цэцэрлэгийн өргөтгөл, БЗД-ийн 6-р хорооны 100 ортой цэцэрлэгийн барилга, БЗД-ийн 6-р цэцэрлэгийн барилга, БЗД-ийн 14-р хорооны 150 ортой цэцэрлэгийн барилга, СХД-ийн 12-16-р хорооны 60 ортой цэцэрлэгийн барилга, ЧД-ийн 12-р хорооны 60 ортой цэцэрлэгийн барилга, БЗД-ийн 5-р хорооны 100 ортой цэцэрлэгийн гал унтраах 14-р ангийн депо зэрэг 2009 оны төсөвт тусгагдсан барилгуудыг барьж ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулна	БХБТГ, НГА
15.		Улаанбаатар хотын газар хөдлөлтийн зураглалыг шинэчлэн боловсруулсан судалгааны ажлын үр дүнг инженер сейсмологийн судалгаа хийх нийтлэг норм дүрэмд нийцүүлэн тодотгох хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж зураг төсөлд мөрдүүлэх ажлыг зохион байгуулна	ХХБХ БХБТГ
Хот орчмын бүс, хотын захын нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд шаардагдах дэд бүтцийн хангамжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж хотын төвийн газар ашиглалтын нягтралыг сааруулна.			
16.		Хотын захын дүүргүүдэд хүнсний ногоо, малын тэжээл тариалах болон үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ барилга байгууламж барих зориулалтаар олгосон газрын төлбөрийг 4 жилийн хугацаанд чөлөөлөх асуудлыг боловсруулж, Засгийн газарт оруулна	БХБТГ
17.		Баянголын амны орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, бий болсон дэд бүтцийн хангамжийн ашиглалтыг хангана	
18.		Хотын нөөц талбай болох Аргалант, Сонсголонгийн болон Налайхын авто замын дагуу, Налайх-Багахангайн замын тойруу орчим зам дагасан хөгжлийг тэтгэсэн орон сууцны хороолол, хотхон байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж, төлөвлөлт хийнэ	
19.	3.1.4	Буянт-Ухаа Хөшгийн хөндийг холбосон авто замын дагуух газрыг хамгаалалтанд авч стратегийн ач холбогдол бүхий шинэ хороолол, хотхон байгуулах төсөл боловсруулан гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцлийг бүрдүүлнэ	
20.		Онцгой объектууд нефть бүтээгдэхүүн, шатдаг хий боловсруулах үйлдвэр, агуулах, химийн болон хорт бодис ашиглан үйлдвэрлэл эрхэлдэг бизнесийн нэгжүүд, арьс шир, ноос, ноолуурын анхан шатны боловсруулалтын үйлдвэрүүдийг хотоос гаргах асуудлыг боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ	
21.		Бүх төрлийн ачаа ачих, буулгах, хадгалах ажиллагааг хотын төвөөс гадагшлуулж, «Ачаа тээврийн төрөлжсөн терминаль»-ийг хотын баруун, зүүн хэсэгт байршуулна	
22.		Хүнд даацын машин механизмын зогсоолыг хотоос гадагшлуулж, ачаа тээврийн замын маршрутыг тогтоож мөрдүүлнэ	
Гэр хорооллын хөгжлийн стратеги, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө» төслийг хэрэгжүүлж, оршин суугчдын амьдрах орчин нөхцлийг сайжруулна.			

23.		Гэр хорооллын өмчлөгдсөн газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Үүнд: Дамбадаржаа, Хужирбулан, Нисэх, Ханын материал, Толгойтын зүүн салаа, Баянзүрхийн товчоо орчим, Биокомбинат орчмын гэр хороолол	БХБТГ
24.	3.1.10	Алслагдсан гэр хорооллын инженерийн хангамжийг өөрийн эх үүсвэрээр хангах замаар ахуй нөхцлийг сайжруулах Загвар төслийг хэрэгжүүлж эхэлнэ. • Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны Горькийн 18-19, 36-37 дугаар гудамжны 2.2 га	
25.		• Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны Шархадны 38, 39 дүгээр гудамжны 3.1 га	
26.		• Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны Их нарангийн 6, 7, 8 дугаар гудамжны 1.2 га	
27.		• Сүхбаатар дүүргийн 17 дүгээр хорооны Дамбадаржаагийн 30, 31 дүгээр гудамжны 3.1 га	
28.		• Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Шархадны 38-39 дүгээр гудамжны 1.5 га	
29.		• Хан-уул дүүргийн 9 дүгээр хорооны Буянт Ухаагийн 18, 19 дүгээр гудамжны 6.5 га	
Орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг цогцолборлоор хэрэгжүүлж, хүн амын тав тухтай орчинд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэн хүн, амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.			
30.		Орон сууцны хорооллуудын батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажилтын төсөл боловсруулж газар зохион байгуулалт, барилгажилтын үйл ажиллагааны нэгдлийг хангах замаар газрын зөрчил, маргааныг барагдуулан зураг төслийн үр ашгийг нэмэгдүүлнэ. Үүнд: • Ногоон зоорь орчмын орон сууцны хороолол /100.0 га/	НГА, БХБТГ
31.	3.1.4	• Амгалангийн зам дагуух орон сууцны хороолол /60.0 га/	
32.		• Чингисийн өргөн чөлөөний дагуух барилгажилт /13.9 га/	
33.		• Яармагийн орон сууцны хороолол	
34.		• «Буянт-Ухаа» орон сууцны хороолол	
35.		• Хотын шинэ төв /965.0 га	
36.		• Дарь-Эхийн II ээлж	
37.		Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийн I үе шатыг /2008-2011/ хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээ, барилгажилтын ажил эхлүүлнэ. Үүнд: 3.1.5 • Орон сууцны 7 дугаар хороолол	БХБТГ
38.	3.1.5	• Орон сууцны 14 дүгээр хороолол	
39.		• МҮОНРадио телевизийн орчны орон сууцны хороолол	
40.	3.1.4	Ар Зайсангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлого боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллана	
41.	3.1.6	Орон сууцны хорооллын барилгажих талбайд бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байгаа газрыг орон сууцаар солих буюу тусгай хэрэгцээнд авах, худалдан авах, зориулалтыг өөрчлөхтэй холбогдсон эрхзүйн баримт бичиг журам, аргачлалыг тодорхой болгож хуульчлах ажлыг зохион байгуулна	НГА

42.		Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжинд барилгажих хорооллын иргэдийг нүүлгэн шилжүүлэх газрын байршил, хэмжээг тогтоож, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний дагуу газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ	НГА
43.	3.1.7	Газар хөдлөлтийн арга хэмжээ тусгагдаагүй болон «Хүн амьдрах шаардлага хангахгүй» нийтийн орон сууцны талаар цаашид баримтлах бодлогын санал боловсруулан, шийдвэрлүүлнэ	ХХБХ, СЭЗТСХ
Орон сууцны хороолол, суурьшлын бүсийн газарт дахин төлөвлөлт хийж хэрэгжүүлэх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх ба орон сууцны санхүүжилтийн зээлийн тогтолцоог бүрдүүлнэ.			
44.		Хотын төвийн 40, 50 мянгатын орон сууцны хороололд дахин төлөвлөлт хийнэ	БХБТГ
45.	3.1.8	Суурьшлын бүсэд агуулах, аж ахуйн зориулалтаар ашиглагдаж буй газарт дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг зохион байгуулна <ul style="list-style-type: none"> «Голден парк» орон сууцны хорооллын эхний ээлжийн 2000 айлын орон сууцны барилгыг барьж ашиглалтанд оруулна /Материал импекс ХХК-ийн эзэмшил газар/ 	
46.		<ul style="list-style-type: none"> «Солонго» орон сууцны хорооллын эхний ээлжийн 3000 айлын орон сууцны барилгыг барьж ашиглалтанд оруулна /Бөөний худалдаа ХХК-ийн эзэмшил газарт/ 	
47.	3.1.17	Орон сууцны хороолол бүхий газруудыг газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамруулах ажлыг зохион байгуулна	НГА
48.	3.1.9	Шинээр баригдаж буй орон сууцны хороололд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бага орлоготой өрхөд зориулсан түрээсийн орон сууцны барилгыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1000 айлын нийтийн орон сууцны барилга барих ажлыг эхлүүлнэ	БХБТГ
49.	3.1.8	Орон сууцны санхүүжилтийн зээлийн тогтолцоог боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлүүлнэ	СЭЗТСХ ХХБХ
50.		Бага, дунд орлоготой өрхүүдийг орон сууцжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг хандивлагч орнууд, олон улсын банк санхүүгийн байгууллагад тавина	
51.	3.1.9	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй болон гачигдалтай иргэд, төрийн албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцаар хангах зорилгоор «Нийслэлийн орон сууцны фондыг зарцуулах журам» боловсруулж, НИТХ-д өргөн барина	НӨХГ
52.	3.1.10	Дэд бүтэц, хот байгуулалтанд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих, тодорхой хугацаанд ашиглуулах, ажиллуулсаны дараа төрд шилжүүлэн өгөх эрх зүйн орчинг бий болгоход холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана	БХБТГ
53.		Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийнэ	
Хот байгуулалт, барилгажилтийн талаархи хууль, норм, стандартыг хэрэгжилтийг чангатгаж нийтийн эзэмшлийн зам талбайн ашиглалтыг сайжруулан хотын соёлжилтын төвшинг дээшлүүлнэ.			

54.	3.1.15	Гудамжны улаан шугам, эрүүл ахуйн болон инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн эдлэн газар, нийтийн эзэмшлийн талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн газрыг хамгаалалтанд авч, авто замын болон явган хүний замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана	НГА
55.	3.1.11	Нийтийн эзэмшлийн зам талбай, автомашины болон явган хүний зам, замын хөдөлгөөнд саад учруулсан, хотын өнгө үзэмжид сөрөг нөлөө үзүүлэхүйц төрөл бүрийн хашаа, түргэн үйлчилгээний цэг, павильон, автотасварын зориулалт бүхий вагончик, тос тосолгооны материалын үйлчилгээний цэгүүдийг журамлана	НГА
56.	3.1.12	Нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлэг, шугам сүлжээг эрчим хүчний хэмнэлттэй технологиор бүрэн шинэчлэх, гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах, нийгмийн зар сурталчилгааг дэмжиж, түүнд зориулагдсан гадна реклам, мэдээллийн байгууламжуудыг бий болгоно	ЗАА
57.		Гудамж талбайн гэрэлтүүлгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, гэрэлтүүлгийг цогцолбороор нь шийднэ	
58.	3.1.16	«Улаанбаатар хотын хаягжуулалтын төсөл»-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулан үйлчилгээний байгууллагууны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангана	
59.	3.1.15	Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр баригдах үйлдвэрлэл, үйлчилгээ, олон нийт, орон сууцны барилга байгууламж барьж үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдээс «Бүтээн байгуулалт»-ын нэг удаагийн татвар авч, «Хот байгуулалтын сан» бүрдүүлэх ажлыг зохион байгуулна	БХБТГ
60.		Нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, хот нийтийн аж ахуйг шинээр барьж байгуулах, сэргээн засварлах, тохижуулахад зориулан үл хөдлөх эд хөрөнгийн татварын тодорхой хувиар бүрдэх сан бий болгох санал боловсруулна	
Газар зохион байгуулалтын зохистой бодлогыг хэрэгжүүлж газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.			
61.		Үндэсний газрын мэдээллийн системийг байгуулах төслийн хүрээнд Улаанбаатар хотын нэгдсэн мэдээллийн санг байгуулах, газрын мэдээллийг нууцын зэрэглэлээс гаргах асуудлыг шийдвэрлүүлнэ	
62.	3.1.18	Кадастрын зургийн мэдээллийн сангийн сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, нийслэлийн нутаг дэвсгэр дэх газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчдийн талаарх мэдээллийг тоон хэлбэрт оруулж нэгдсэн санд төвлөрүүлнэ	
63.		Газар эзэмших эрхийн барьцааны бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг эхлүүлэн үүнтэй холбоотой үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох санал боловсруулан НИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ	
64.		Газрын үнэлгээний бүсчлэлийн хил хязгаарыг шинэчлэн, газрын төлбөрийн хэмжээг ялгавартай тогтоох санал боловсруулж шийдвэрлүүлнэ	
65.	3.1.19	Нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүргүүдийг холбосон улсын чанартай авто замын дагуух газрыг Нийслэлийн эдэлбэр газарт шилжүүлэх санал боловсруулна	НГА
66.		Улсын Тусгай хэрэгцээний газрыг баталгаажуулах, улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын асуудлыг зохицуулах эрх зүйн асуудлыг шийдвэрлүүлнэ	
67.	3.1.20	Өмчлүүлсэн газрыг гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлэх, бусад гишүүдэд хууль тогтоомжинд заасны дагуу газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулна	
68.	3.1.21	Иргэдийн өмчлөгдсөн газрын бирж байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ	
69.	3.1.22	Нийслэлийн ногоон бүсэд зуслангийн зориулалтаар иргэдэд газар өмчлүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлүүлнэ	

3.2 АВТО ЗАМ Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу олон түвшинд огтлолцсон уулзвар, гүүрэн гарцууд барих ажлыг эхлүүлж, авто зам, гүүр, замын байгууламжуудын шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлнэ.			
70.	3.2.1	БНСУ-ын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр «Улаанбаатар хотын зам тээврийн оновчтой систем» төслийг хэрэгжүүлнэ	НАЗГ
71.	3.2.3	Япон улсын ЗГ-ын буцалтгүй тусламжаар Энгельсийн гүүрийн барилгын ажлыг эхлүүлнэ	
72.	3.2.1	Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлээр Хайлаастын 1,1 км, Баруун салааны 3,6 км, Орбит-Тахилтын 5,6 км авто замыг барина	
73.	3.2.4	Сүхбаатар, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр дэх Дамдинсүрэнгийн гудамжны авто замыг барина	
74.		Туул голын, Тэрэлж дэх горхийн 211 у/м төмөр бетон гүүр барина	
75.		Их тэнгэрийн 258 у/м төмөр бетон гүүрийг барина	
76.		Баруун 4 зам-Зүүн 4 дах 3.6 км автозамыг шинэчилнэ /гүүрийн хамт/	
77.		Баруун 4 замаас 10-р хорооллын уулзвар хүртэлх 1.6 км автозамыг өргөтгөн шинэчилнэ	
78.		Баруун 4 замаас Баянбүрд, 100 айл, Сэлбийн гүүр хүртэлх Их тойруугийн 3.8 км замыг өргөтгөн шинэчилнэ	
79.		Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр дэх Сүхбаатарын гудамжны 2 км автозамыг шинэчилнэ	
80.		Нарны замын, 10-р хорооллын өмнөх замын уулзвараас урагш Төмөр замын вокзал хүртэлх баруун хэсэг, Нарантуул захын уулзвараас Чулуун овоотын уулзвар хүртэлх зүүн хэсгийн 3.6 км авто замыг өргөтгөнө	
81.	3.2.3	Энхтайвны өргөн чөлөөнд «Ионсей» эмнэлгийн өмнөх замд явган хүний нүхэн гарц байгуулна	
82.	3.2.4	Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр дэх Нарангийн энгэрийн хогийн цэг хүртэлх 1.2 км авто замыг гэрэлтүүлгийн хамт барина	
83.	3.2.3	Саппорогийн аюулгүйн тойргийн 2 түвшний огтлолцолт замыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн барих ажлыг эхлүүлнэ	
84.		Яармагийн гүүр-Баянзүрхийн товчоо чиглэлийн 17 км транзит замыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн барих ажлыг эхлүүлнэ	
<u>НИЙТИЙН ТЭЭВЭР</u> Улаанбаатар хотын тогтвортой тээврийн стратегийг боловсруулж, нийтийн тээврийн зорчигч урсгалын судалгааг үндэслэн маршрут болон замын хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах замаар зорчигч тээврийн үйлчилгээний тогтвортой системийг бий болгоно.			

85.	3.2.8	Улаанбаатар хотын тогтвортой тээврийн стратеги болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаатайгаар боловсруулна	ХХБХ НТГ
86.	3.2.12	Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны мэргэшсэн жолооч бэлтгэх, жолооч, кондукторуудыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, хөдөлмөрийн нөхцлийг өмчийн хэлбэрээр ялгалгүй хүнд нөхцөлд хамруулах асуудлыг шийдвэрлүүлнэ	ХХБХ НТГ
87.	3.2.8	Улаанбаатар хотын доторх аюултай ачаа, хүнсний технологийн болон ахуйн тээвэр, авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бий болгох, үйлчилгээ эрхлэгчдийг зэрэглэх, аттестатчилах, тээвэрлэлтийн ажил эрхлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно	НТГ
88.	3.2.14	Нийтийн тээврийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ	
89.	3.2.9	Нийтийн тээврийн паркыг 400 автобус, 20 дуобус болон троллейбусаар шинэчилнэ	ХХБХ, НТГ
90.	3.2.8	Дахин дамжуулах станцуудыг шинээр байршуулах байршлыг тодорхойлон 10 цэгт байгуулж, автобусны хөдөлгөөний бүртгэл хяналтын станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ	
91.	3.2.10	Автобусны буудал зогсоолыг тохижуулж, чиглэлийн замнал, хөдөлгөөний цагийн хуваарь хаяг тавина	НТГ
92.		Нийтийн таксийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн тоо, зогсоолын талбайг нэмэгдүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулна	
93.		3.2.14	
<p><u>3.3 ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААН ХАНГАМЖ</u> <i>Цахилгаан эрчим хүчний техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг үргэлжүүлж, хангамжийг сайжруулна. Дулааны гол шугамуудыг өргөтгөн шинэчилж, шинэ хорооллуудыг төвлөрсөн дулаанаар хангана.</i></p>			
94.	3.3.1	Багануур дүүргийн дулаан хангамжийн системийг үл хамаарах системд шилжүүлэх ажлыг эхлүүлнэ	ЗАА
95.		ДЦС 2-ийг түшиглэн дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлш болон хийгээр эрчим хүч үйлдвэрлэх цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ	
96.		ДЦС 4-д усны дулаан солилцуулагч бүхий дулааны дэд станц барих, станцын дотоод шугам сүлжээг шинэчлэх, шинээр сүлжээний насос суурилуулах ажлыг эхлүүлнэ	
97.		Дулааны насос станц № 1, 6 –ийн хүчин чадлыг нэмэгдүүлж шинэчлэх ажлыг эхлүүлнэ	
98.		Дулааны бие даасан, бага оврын эх үүсвэх байгуулах судалгааны ажил хийлгэнэ	
99.	3.3.1	Экологид ээлтэй халаалтын зуухны шинэ технологийн үр дүнд дүгнэлт гаргуулах, уг технологийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ	ХХБХ, ЗАА, АЧА
100.	3.3.2	Эрчим хүчний шинээр баригдах тав дахь үүсгүүрийн эхний хэсгийг барих ажлыг эхлүүлнэ	ХХБХ

101.	3.3.4	Улаанбаатар хотын дулаан хангамжийн эх үүсвэр болон гол шугамыг өргөтгөн, шинэчилж дулаан хангамжийн хүртээмжийг сайжруулж орон сууцны шинэ хорооллуудыг төвлөрсөн дулаанаар хангах нөхцлийг бүрдүүлнэ. Үүнд:	3АА
102.		• Дулааны 7В магистралийн 950м хос 500мм голчтой шугамыг 700мм голчтой болгоно	
103.		• Дулааны 12Б магистралийн өргөтгөн шинэчилнэ	
104.		• Дулааны 5Б магистралийн 500мм-ийн голчтой 1950м хос шугамыг 800 мм голчтой болгоно	
105.		• Дулааны 7И магистралийн 837м хос 400мм голчтой шугамыг 500мм голчтой болгоно	
106.		• Дулааны 6Б магистралийн 1050м хос 500мм голчтой шугамыг 600мм голчтой болгоно	
107.		• Дулааны 6В магистралийн 1148м хос 500мм голчтой шугамыг 600мм голчтой болгоно	
108.		• Дулааны станцын зуухны шинэчлэлт /Багануур/ • Дулааны станцын зуухны утаа сорогч, үнс зайлуулах системийн шинэчлэлт /Налайх/	
109.	3.3.7	Ил хуваарилах байгууламж 220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын өргөтгөлийг хийнэ	3АА
110.	Ил хуваарилах байгууламж 4-д 220/110/35 кВ-ын 125 мВа чадалтай авто трансформатор суурилуулах ажлыг эхлүүлнэ		
111.	Умард дэд станцын трансформатор, хаалттай хувиарлах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хийлгэнэ		
112.	Эмээлтэд 2х1.6мВа хүчин чадалтай 35/10 кВ дэд станц байгуулж, 4км цахилгаан дамжуулах шугам татах		
113.	3.3.6	Хайлааст дэд станцаас Яргайтын дэд станц хүртэл 35кВ-ийн 2 хэлхээт 9км цахилгаан дамжуулах шугам шинээр татана	
114.	СХД, ХУД, БЗДүүргийн гэр хорооллын айл өрхийн цахилгааны хүчдэлийг сайжруулж, шинээр суурьшсан гэр хорооллыг цахилгаан эрчим хүчээр хангана		
115.	6, 10 кВ-ын дэд станцуудын тосон таслууруудыг вакуум болгох /РП 3, 5, 6, 13, 24/ ажлыг эхлүүлнэ	3.3.8	
116.	Шинээр баригдах орон сууцны хорооллуудад газар доорхи инженерийн шугам сүлжээний хонгилын системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ		
<u>3.4 УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА</u>			
<i>Хүн амын ус хангамжийн найдвартай ажиллагааг хангахаар ус хангамжийн шинэ эх үүсвэр бий болгон эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг бохирдлоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</i>			
117.	3.4.3	Туул, Тэрэлжийн голуудын урсацыг ашиглан ус хуримтлуулах далангууд байгуулах техникийн эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг эхлүүлнэ	ХХБХ, УСУГ
118.	3.4.3	Хотын баруун бүсийг ундны усаар хангах тооцоо, судалгаа хийх, зураг төслийг боловсруулж эхэлнэ	УСУГ
119.	Усан хангамжийн «Гачуурт» шинэ эх үүсвэрийг барих бэлтгэл ажлыг хангана		
120.	3.4.4	Усан хангамжийн эх үүсвэрүүдийн ариун цэвэр, хамгаалалтын мужийн заагийг тэмдэгжүүлж, Гачуурт тосгон хүртэл автозам дагуу 4 км үрт хамгаалалтын хашлага хийнэ	3АА , УСУГ

Гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, орон сууцны байгууллагын харъяа ус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж, шугам сүлжээг шинэчилэх, хэрэглэгчдийг тоолууржуулах замаар усны зүй бус хэрэглээ, алдагдлыг багасгана.				
121.	3.4.5	Нийтийн аж ахуйг сайжруулах 2 дахь төслийн хүрээнд: - Баянхошууны гэр хороололын усан хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтанд өгнө		ХХБХ, ТУН
122.		- Дарь эхийн гэр хороололын усан хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтанд өгнө		
123.		- Дамбадаржаагийн гэр хороололын усан хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтанд өгнө		
124.		- Дамбадаржаагийн гэр хороололын 70 айл өрхийг усан хангамжийн шугам сүлжээнд холбоно		
125.	3.4.6	Траншейгүй аргаар цэвэр, бохир усны шугамыг суурилуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, 1.2 км цэвэр усны дамжуулах шугамын доторлогоо хийх. Цэвэр усны шугамыг доторлох шинэ технологи нэвтрүүлнэ		УСУГ, НААСТ
126.	3.4.7	Төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон нийт айл өрхийг тоолууржуулах ажлыг үргэлжлүүлнэ		ОСНААУГ
127.	3.4.8	Ахуйн хэрэглээний цэвэр усны үнэ, бохир усны төлбөрийг нэмэгдүүлэх боломжийг судлаж, хэрэгжүүлнэ		ХХБХ, УСУГ
128.	3.4.9	62-р цэцэрлэг, 27 айлын орон сууцны гадна дулаан, ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ /БЗД, 10-р хороо/		ЗАА
129.		Орон сууцны компаниудын харьяанд байгаа хорооллын гадна, доторх дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэнэ		
130.		Солонгос улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжих Ус дулаан дамжуулах төвүүдийн халуун хүйтэн усны насос, тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийг хэрэгжүүлнэ		
Шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг барьж байгуулахад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж, өргөнөөр татан оролцуулах арга хэмжээ авна.				
131.	3.4.11	Засгийн газрын бондын хөрөнгөөр баригдах орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эхлүүлнэ		НБХБТГ
132.		Баянголын амнаас Найрамдал зуслан хүртэлх инженерийн шугам сүлжээ барих 3 дугаар ээлжийн ажлыг дараа төлөх нөхцөлтэйгөөр эхлүүлнэ		ЗАА
133.		Олимпийн хотхоны гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эхлүүлнэ		
134.		Улаанбаатар хотын баруун урд үйлдвэрийн районы цэвэр бохир усны шугам сүлжээний барилга угсралтын ажлыг дуусгана		НБХБТГ
135.		Шинээр баригдах 14-р хорооллын 6-р хэсгийн дулаан, цэвэр, бохир усны шугам, өргөтгөлийн насос станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ		ЗАА
136.		Буянт-Ухаа орон сууцны хорооллын цэвэрлэх байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл боловсруулна		НБХБТГ УСУГ
Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээг өргөтгөн, шинээр барьж байгуулан, бохир ус цэвэрлэх, цэвэршүүлэн дахин ашиглах оновчтой техникийн шийдлийг бий болгон хэрэгжүүлж хөрсний бохирдлоос хамгаална.				
137.	3.4.3	Ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг дахин цэвэршүүлэн ашиглах технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана		УСУГ
138.	3.4.11	Төв цэвэрлэх байгууламжийн техник технологийг шинэчлэх төслийн 2-р ээлжийн ажлыг дуусгана		

139.		Бохир усны Туул-1 гол коллекторын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ /34.9 км/	НБХБТГ
140.	3.4.12	Бохир усны 25-р коллекторын 2-р ээлжийн ажлыг дуусгана	
141.		3, 4-р хорооллын 31-ийн 3-р коллекторын ф500мм-ийн бохир усны шугамын өргөтгөл, шинэчлэлтийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ	
142.	3.4.13	Арьс ширний анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулна	ХХБХ
143.	3.4.12	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн /бие засах газар/ болон бага оврын цэвэрлэх байгууламжийн норм стандартыг бий болгоно	ЗАА
Үерийн хамгаалалтын далан сувгийг цэвэрлэж, засварлах, шинэчлэн өргөтгөх ажлыг зохион байгуулна			
144.	3.4.14	Үерийн хамгаалалтын далан сувгийг цэвэрлэж, засварлах ажлыг зохион байгуулна	ЗАА
145.		Чингэлтэй, Хайлаастын үерийн далан сувгийг шинэчлэх зураг төслийг боловруулж дуусгана	ЗАА «УББ» НӨҮГ
Нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн судалгаа авч, цахим хэлбэрт шилжүүлэх, шилжсэн мэдээллийг нэгдсэн стандартад оруулах асуудлыг судлах. Нутгийн захиргааны байгууллагуудыг холбосон сувагчлал бүхий өндөр хурдтай нэгдсэн сүлжээнд холбох бэлтгэл ажлыг хангана			
146.	3.6	Нутгийн захиргааны 10 байгууллагын мэдээллийн урсгалын анализ дизайн, архитектурыг гаргана	НМТГ
147.		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад мэдээллийн сан үүсээгүй байгаа 20 байгууллагад үйл ажиллагааны чиглэлийн дагуу холбогдох мэдээллийн сангуудыг үүсгэнэ	

ДӨРӨВ. ЭКОЛОГИ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР

№	Заалтын дугаар	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
Агаарын бохирдлыг багасгана.			
1.	4.3.	Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын 5000 доошгүй айл өрхөд Ёнтан зуух, түлш хэрэглүүлэх ажлыг зохион байгуулна	БХГ
2.		Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн гэр хорооллын 10000 доошгүй айл өрхөд үртсэн болон нүүрсэн шахмал түлш хэрэглүүлэх ажлыг зохион байгуулна	
3.	4.1.	Дэлхийн банкны шугамаар хэрэгжих «Цэвэр агаар» төслийн хэрэгжилтийг зохион байгуулна	ХХБХ, АЧА
4.		Японы Жайка байгууллагын шугамаар хэрэгжих Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чадавхийг бэхжүүлэх төслийн эхний үе шатыг хэрэгжүүлнэ	
5.		Европын сэргээн босголт хөгжлийн банкны «Цэвэр агаар» хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг судлана	
6.	4.3.	Төгрөг нуурын энерги компаний үйлдвэрлэх 20000 тн коксжсон түлшийг Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын хэрэглээнд нэвтрүүлнэ	БХГ
7.		Хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэлд өрсөлдөөн бий болгох, энэ талаар хувийн хэвшлийн санаачилгыг бүх талаар дэмжинэ	ХХБХ
8.		Хэрэглээнд байгаа төрөл бүрийн шахмал түлшнүүдийн шаталтаас үүсэх агаар орчныг бохирдуулагч хорт хийнүүдийн агуулгыг судлаж стандартын шаардлага хангасан түлшнүүдийн сонголтуудыг хийх, үүнийг үндэслэн зуух-түлшний зохистой хувилбарыг сонгоно	БХГ
9.	4.1.	«Автомашингүй өдөр»-ийг хот, дүүргийн хэмжээнд зохион байгуулж хэвшүүлэх, шаардлага хангахгүй автомашины утаанаас болж агаарын бохирдол үүсэж байгаа талаар иргэдийн дунд сурталчилгааг эрчимжүүлнэ	ЗЦГ
10.		Авто тээврийн хэрэгслүүдийн утаанд хэмжилт хийж, илэрсэн зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авах, утаа ихтэй тээврийн хэрэгслийг авто замын хөдөлгөөнд оролцуулахыг хязгаарлана	БХГ, ЗЦГ
11.		Хотын агаарын бохирдол их 4 цэгт суурин харуул байрлуулна	БХГ
Хотын ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг сайжруулах замаар ногоон орчныг дэвжүүлнэ.			
12.	4.10.	Хотын ногоон байгууламжийн арчилгааг хариуцдаг мэргэжлийн албыг хотод байгуулах боломжийг судлана	ЗАА
13.		Хорооллын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүрэг бүрт орон сууцны нийтийн эзэмшлийн талбайд 2 доошгүй бичил цэцэрлэг бий болгоно	
14.		Хотын ногоон байгууламжийг нягтруулах, том оврын модыг шилжүүлэн суулгах замаар шилмүүст модны эзлэх хувийг нэмэгдүүлнэ	
15.	4.11.	Цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын бүсийг цэцэрлэгжүүлэх ажлыг зохион байгуулна	
16.	4.12.	Гэр хорооллыг цэцэрлэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ	
17.	4.11.	Төвлөрсөн усан хангамжийн хамгаалалтын бүсийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлнэ	ЗАА

18.	4.8.	«Ногоон хэрэм» хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 15.0 га газарт ойн үндсэн зурвас байгуулах, Сэлбэ голын эх, Баянзүрх ууланд 200.0 га газарт ойжуулалт хийнэ	БОГ
19.	4.8.	Туул, Сэлбэ голын сав газрыг хамгаалах ажлын хүрээнд Үндэсний парк байгуулах ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ / 930.0 га/	БХБТГ
Нийслэлийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулна.			
20.	4.18.	Улаанчулуутын төвлөрсөн хогийн цэгийн хуучин хог хаягдлыг ландшафт технологийн дагуу дарж булах, хөрсөөр хучиж эрүүлжүүлэн хаана	ХТГ
21.		Дүүргүүдийн нутаг дэвсгэрт үүссэн ахуйн болон барилгын хур хогийг цэвэрлэн зайлуулна	ХТГ
22.		Хог хаягдлын зориулалттай машин техникийн тоог нэмэгдүүлж, шинэчилнэ	ЗАА
23.	4.19.	Барилгын хог хаягдлын зориулалтын цэгтэй болох асуудлыг шийдвэрлүүлнэ	ЗАА, ХТГ, НМХГ
24.		Химийн хортой болон аюултай хог хаягдал хаях цэг байгуулах ТЭЗҮ боловсруулна	ЗАА, ОБГ
25.		Эмнэлгийн болон тусгай хог хаягдлын зориулалтын цэг байгуулна	ОБГ, НМХГ ЗАА, НЭМГ
26.	4.17.	Хог ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах төсөл шалгаруулна	ЗАА, ХТГ
27.		Нарангийн энгэрийн шинэ хогийн цэгийг хүлээн авч ашиглалтанд оруулна	ЗАА, ХТГ
28.		Японы техник хамтын ажиллагааны төслийн эхний үе шатыг хэрэгжүүлнэ	
Байгаль хамгаалах менежментийн тогтолцоог сайжруулж, зөрчлийг бууруулна.			
29.	4.23.	Нийслэлийн ногоон бүсэд тавих хяналт шалгалтыг сайжруулах, зөрчил гаргагчдад хүлээлгэх хариуцлагыг чангатгана	БХГ
30.	4.23.	Байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарын уулзалт, семинарыг улирал бүр зохионо	
31.		Нийслэлийн ногоон бүсийн байгаль орчныг хамгаалах талаар Цагдаагийн газар, Замын цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, дүүргүүдтэй хамтран ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ	
32.		Нийслэлийн ногоон бүсийн ойн сан бүхий газруудыг гэрээгээр эзэмшүүлнэ	
33.	4.23.	Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар даалгавар өгч, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллана	
34.	4.23.	Ойг хөнөөлт шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна	
35.	4.23.	Налайх, Багануур дүүргийн нүүрсний уурхайн хуучин ашиглалт явуулсан газар болон Баянгол дүүргийн ТЭЦ-3 орчмын эвдэрсэн газарт хөрсний нөхөн сэргээлт хийнэ	БОГ

ТАВ. ЭРХ ЗҮЙ, НУТГИЙН ЗАХИРГААНЫ АЖЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААР

№	Заалтын дугаар	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
Нийслэлийн эдийн засаг, нийгмийн амьдралтай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулна.			
1.	5.1	Нийслэлийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд «Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай» хуулийн төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулна	ХЗХ
2.		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд чирэгдэл учруулж буй эрх зүйн баримт бичгийг хянан үзэж шинэчилж, хүчингүй болгоно	
Төрийн үйлчилгээний нээлттэй, шударга, шуурхай байдлыг ханган албан хаагчдын ажлын хариуцлага, санаачилга, чадварыг дээшлүүлж, «Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээ» байгуулж ажиллана.			
3.	5.2	«Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээ»-г төрийн албан хаагчидтай байгуулж, дүгнэнэ	ХЗХ ТЗУХ
4.		Нийслэлийн «Авилгалтай тэмцэх хөтөлбөр»-ийг шинэчлэн өөрчилж, хэрэгжүүлнэ	ХЗХ
5.		Төрийн албан хаагч, албан тушаалтны сахилга, ёс зүй, төрийн үйлчилгээтэй холбоотой иргэдийн санал, хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авч хариуцлага тооцож ажиллана	ТЗУХ
6.		Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг 2009-2012 онд хангах дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ	
Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, удирдлагын манлайллыг хангана.			
7.	5.3	Удирдлагын Академитай хамтран захиалгат сургалтыг зохион байгуулж 50-иас доошгүй төрийн албан хаагчдыг оролцуулна	ТЗУХ
8.		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор сэдэвт сургалтыг 4 удаа зохион байгуулна	
Дүүрэг, хороог бэхжүүлэн, үйл ажиллагааг нь өргөжүүлж, «Хороо» хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.			
9.	5.4	«Төрийн албаны тухай хууль»-нд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хороодын Засаг дарга нараас төрийн албаны шалгалт авах, төрийн албаны тангараг өргүүлэх, төрийн захиргааны албан тушаалд томилох ажлыг зохион байгуулна	ТЗУХ
10.		Засаг захиргааны анхан шатны нэгж болох нийслэлийн хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хорооны Засаг дарга, өрхийн эмнэлэг, цагдаагийн нэгдсэн байр 10-г шинээр барина	
11.		Хороо тус бүрт 2 сая төгрөг олгоно	СЭЗТСХ
Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээнд нэг цэгийн болон угтах үйлчилгээг хэвшүүлнэ			

12.	5.5	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 3 дугаар байранд «Угтах үйлчилгээ»-г зохион байгуулна	НҮГ
13.		Нийслэл, дүүргийн газрын алба, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, Чингэлтэй дүүрэгт нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлнэ	ТЗУХ, НГА, НШГА
Хуулиар зөвшөөрөгдсөн мэдээлэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд нээлттэй болгоно.			
14.	5.6	Нийслэлийн төсвийг төлөвлөх, хянах, хэлэлцүүлэх, батлах, хуваарилах, зарцуулах, тайлагнах үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох замаар ил тод байдлыг хангана	СЭЗТСХ
15.		www.ulaanbaatar.mn , www.mayor.mn , www.citycouncil.mn веб хуудсуудаар нийслэлийн удирдлагууд болон нутгийн захиргааны байгууллагуудаас хийж хэрэгжүүлж байгаа ажлыг олон нийтэд цаг алдалгүй сурталчилна	ТЗУХ
16.		Нийслэлийн 370 жилийн ой угтсан ажлаар нийслэлийн иргэдийн нийтлэг эрх ашиг, хүсэл сонирхолд нийцсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, мэдээллийн хэрэгслээр сурталчилна	Ажлын хэсэг
Нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлнэ.			
17.	5.7	Нийслэлийн Газрын албаны вэб сайтад хууль тогтоомж, мэдээ мэдээлэл, Нийслэлийн 2009 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны зарлал, газар олголт, баталгаажилтын захирамж зэргийг байршуулан, тогтмол шинэчилнэ	НГА НМТГ
18.		Нийслэлийн нутгийн захиргааны 30 байгууллагын албан хаагчдад мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд сургалт сурталчилгааг зохион байгуулна	НМТГ
19.		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлдэг бүх төрлийн лавлагаа олгох, мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх 3 төрлийн 71 үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлнэ	
20.		Дүүргүүдийн ЗДТГ-т байгууллага, иргэдэд үнэгүй үйлчлэх интернет, компьютерийн танхим байгуулах ажлыг эхлүүлнэ	Дүүргүүд
Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад иргэд, нийгмийн ба сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах зарчимаар иргэдийн санал бодлыг үйл ажиллагаандаа тусгана.			
21.	5.8	Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын удирдлагууд улирал бүр иргэдтэй уулзалт зохион байгуулж, санал бодлыг нь үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллана	ТЗУХ
22.		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд сар болгоны нэг өдөр иргэдэд ажлаа сурталчлан тайлагнана	
23.		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаар өдөр тутмын хэвлэлүүдэд сонины тусгай нүүр гарган иргэдийн санал бодлыг тусгасан хэлэлцүүлэг явуулна	ОНХА
Төрийн зарим чиг үүрэг буюу төрийн байгууллагын эрхэлж байгаа зарим үйлчилгээг иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.			
24.	5.9	Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх боломжтой төрийн үйлчилгээний судалгаа гаргана. Иргэдэд чиглэсэн сургалтыг төрийн бус байгууллагуудаар 2 удаа гүйцэтгүүлнэ	ТЗУХ ХЗХ
Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын зорилтуудын хэрэгжилтийг хангах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанарт ахиц гаргах, нутгийн захиргааны байгууллагуудын үйлчилгээнд хүнд суртал, чирэгдлийг гаргахгүй байлгахад хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг чиглүүлнэ.			
25.	5.10	Нийслэлийн нутгийн захиргааны болон Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллагуудын 2008 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийнэ	ХШҮА

26.		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн 2009 онд дэвшүүлсэн Үндсэн чиглэлээс нийслэлд хэрэгжүүлэх ажил, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2009 оны зорилтын хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргаж, удирдлагуудад танилцуулан, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ	
27.	5.10	Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, удирдлагуудад танилцуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ	ХШҮА
28.		Төрийн ажлын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйлчилгээний чанар, хүртээмжинд өгөх иргэдийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааг нийслэлийн хэмжээнд хийж, судалгааны үр дүнг цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ	
Шилжин ирэгсэд зөвхөн төлөвлөгдсөн бүсэд суурьшин төрийн болон нийгмийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, журамтай шилжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ			
29.	5.11	Шилжин ирэгсэд зөвхөн төлөвлөгдсөн бүсэд суурьшин төрийн болон нийгмийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, журамтай болгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ	ХЗХ
Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчилж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангана.			
30.		Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб цэргийн тоо бүртгэлд бүртгэгдвэл зохих насны эрчүүдийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ	
31.		Багануур дүүрэгт дайчилгааны томилоот бүрэлдэхүүнтэй, Налайх дүүрэгт Орон нутгийн цэргийн бүрэлдэхүүнтэй цэргийн команд штабын сургууль, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт штабын дадлага явуулна	
32.		Цэргийн жинхэнэ албанд татагдсан дайчдад цэргийн нарийн мэргэжил эзэмшүүлэх замаар дайчилгааны бэлтгэл нөөцийг 0,8 хувь, Зэвсэгт хүчний ангиудтай хамтран 8 мэргэжлээр сургалтанд хамруулж, 0,2 хувиар дайчилгааны бэлтгэл нөөцийг тус тус нэмэгдүүлнэ	
33.		Дүйцүүлэх алба хаагчдыг гамшиг осол гарсан газар оронд ажиллахад шаардагдах хөдөлмөр, аюулгүй ажиллагааг хангасан техник хэрэгсэл, хувцас, хангалтын материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ	
34.	5.12	Дүйцүүлэх албан хаагчдыг нийслэл хотод учирч болох гамшиг осол, экологийн аюулын үед ажиллах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулан мөрдөж, «Дүйцүүлэх албан хаагчдын өдөр»-ийг бий болгон жил бүр нийслэлийн бүтээн байгуулалт, хөгжилд хувь нэмэр оруулах бүтээлч ажлыг хийж хэвшүүлнэ	ЦШ
35.		Батлан хамгаалах хууль, тогтоомжийг тусгай төлөвлөгөөний дагуу нийслэлийн хэмжээнд сурталчилан, хэрэгжилтийг дүүрэг, хороо, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тусгай удирдамж, төлөвлөгөөний дагуу жил бүр шалгаж мэргэжлийн туслалцаа үзүүлэн, хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцож, нийтэд мэдээлнэ	
36.		Төрийн тусгай албыг биеэр хаасан иргэн төрийн үйлчилгээг тэргүүн ээлжинд хүртэж байх, ар гэр нь алба хаах хугацаанд нь амьдрал нь баталгаатай байх гэсэн чиглэлийг баримтлан цэргийн жинхэнэ алба хааж байгаа дайчдын ар гэрийн 35 хувь, цэргийн жинхэнэ албанаас халагдаж ирсэн дайчдын 40 хувийг ажлын байраар хангах, мэргэжил олгох сургалтанд хамруулах, буцалтгүй тусламж үзүүлэх, хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах зэрэг төрийн үйлчилгээг үзүүлнэ	
37.		«Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр»-ийн 2009-2012 оны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ	ХЗХ

38.	5.12	Нийслэлийн иргэдийн амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Цагдаагийн хөдөлгөөнт эргүүлийн чиглэлийг 20-иор нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх ажлыг зохион байгуулна	СЭЗТСХ ХЗХ НЦГ
39.		Нийслэлийн хэмжээнд согтууруулах ундааны хэрэглээ, архидалтын хамрах хүрээний талаар мэргэжлийн байгууллагаар бодитой судалгаа, дүн шинжилгээ хийлгэж, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэн, урамшууллын хэлбэрийг бий болгоно	
40.		Архидан согтуурахтай тэмцэх аян өрнүүлэн, нийслэлийн Засаг даргын дэргэд орон тооны бус зөвлөл байгуулна	ХЗХ
41.		Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа «РС» тоглоомын газар, «Миний кино театр», «TV chat»-ийг ажиллуулах журмыг шинэчлэн мөрдүүлнэ	ХЗХ НСУГ
42.		«Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль»-ийн 19 дүгээр зүйлд заасан улсын орлого болгосон торгох ял ногдуулж, төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан зарцуулна	СЭЗТСХ ХЗХ
43.		Захаиргааны зөрчлийн талаарх мэдээллийн цахим сан бүрдүүлнэ.	СЭЗТСХ НЦГ
44.		Цагдаагийн байгууллагын автомашины парк шинэчлэлтийг 6 машинаар нэмэгдүүлж, тусгай хэрэгслийн хангалтыг 147 ш гар станц, 7 ш машины болон суурин станц, 1 ш дахин дамжуулах станц, 285 ш радио станцын тэжээл, 300 ш антенн, 38 ш цэнэглэгчээр нэмэгдүүлнэ	СЭЗТСХ ХЗХ НЦГ
45.		Байгууллага, аж ахуйн нэгжийн автомашины зогсоолын талбайн хөдөлгөөнийг зохицуулах үүрэг бүхий төрийн бус байгууллага байгуулах, нийтийн эзэмшлийн талбай дээр тээврийн хэрэгсэл байрлуулах асуудлыг журамлах төлбөртэй зогсоолын талбай байгуулах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ	ХЗХ ЗЦГ
46.		Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн Замын цагдаагийн тасгийг байртай болгох асуудлыг шийднэ	ХЗХ НӨХГ
47.		Замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн үйлдвэрийг цагдаагийн байгууллагад шилжүүлнэ	
48.		Нийслэл хотод шөнийн эргүүлийн албыг шинээр байгуулах, техник хэрэгслээр хангаж ажиллуулна	СЭЗТСХ ЗЦГ
49.		Замын цагдаагийн газрын дэргэд зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, түүнээс үүсэх хор хохиролыг олон нийтэд сурталчлах, замын хөдөлгөөний дүрмийн сургалт явуулах телестудийг байгуулна	ЗЦГ
50.		Ерөнхий боловсролын сургуулийн авто зам дээр явган хүний гарцын орчимд хурд сааруулагч байрлуулна. Үүнд: -Сүхбаатар дүүрэгт: 57-р сургуулийн урд талын замд, -Баянгол дүүрэгт: 13-р сургуулийн арын замд, 40-р сургуулийн арын замд, 77-р сургуулийн арын замд -Сонгино хайрхан дүүрэгт: 83-р сургуулийн арын замд, 67-р сургуулийн баруун замд, 63-р сургуулийн арын замд, -Хан-Уул дүүрэгт: Механик инженерийн сургуулийн арын замд, -Чингэлтэй дүүрэгт: 39-р сургуулийн урд талын замд, -Баянзүрх дүүрэгт: 14-р сургуулийн дэргэдэх замд, 102-р сургуулийн арын болон урд талын замд, Амгалан цогцолборын туслах замд	НАЗГ ЗЦГ УБЗЗА

Гамшигаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулишгүй сэргээн босгох ажиллагааны үр дүнг сайжруулна.			
51.	5.13	Авто тээврийн шалган бүртгэх товчоодууд дээр суурин, байнгын ажиллагаатай ариутгалын цэг байгуулах бэлтгэл ажлыг хангана	НОБГ НАЗГ
52.		Нөөцийн газар байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ	ХЗХ НОБГ
53.		Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байранд байнгын ажиллагаатай Онцгой комиссын удирдлагын байрыг тоноглож дуусна.	НЗДТГ НОБГ
Төрийн болон байгууллагын архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх болон төрийн архивын хадгалалт хамгаалалтын нөхцлийг хангах үйл ажиллагааг үе шаттайгаар шийдвэрлэнэ.			
54.	5.14	Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийн стандартын хэрэглээг бий болгон, цахим бичиг хэргийн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд «Албан хэрэг хөтлөлтийн программ»-г Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд нэвтрүүлнэ	НАГ ХХБХ НМТГ
55.		Төрийн архивын сан хөмрөгийн үндсэн хэсгийн баримтыг олон улсын стандартын дагуу тодорхойлж, сэдэв асуудлаар эрж хайх боломжийг бүрдүүлэн, «Дансны мэдээллийн сан»-г ашиглалтанд хүлээн авч, мэдээллийг онлайн-аар авдаг болгоно	НАГ
56.		Төрийн архивын барилгын зураг төсвийг гүйцэтгэнэ	СЭЗТСХ НБХБТГ
Улаанбаатар хотод хүн амын бүртгэл, мэдээллийн системийг цахим хэлбэрт үе шаттай хамруулна.			
57.	5.15	Улаанбаатар хотын хүн амын хаягийн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд Маягт 1, ХААТР-11-18, ХААТР-21, ХААТР-22, ХААТР-24 маягтуудыг цахим мэдээллийн сангийн хэлбэрт оруулан эрэлт хайлтыг хурдасгасан программ хангамжийг боловсруулна	НИБМА НМТГ
58.		Иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай ажиллах иргэний бүртгэлийн ажилтнуудын мөрдөн ажиллах стандартыг боловсруулан, хэрэгжүүлнэ	НИБМА
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг шалгуур үзүүлэлтүүдээр статистикийн албан ёсны мэдээг үндэслэн дүгнэнэ. Статистикийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлийг цахим хэлбэрээр гадаад, дотоодын хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээг нэвтрүүлнэ. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогыг зохион байгуулна.			
59.	5.16	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг шалгуур үзүүлэлтүүдээр статистикийн албан ёсны мэдээг үндэслэн дүгнэнэ.	ХХБХ
60.		Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдлын талаарх албан ёсны болон захиргааны мэдээллийн уялдааг сайжруулах, <<Нийслэл хот>> статистикийн 2008 оны эмхэтгэлийг шинэчлэн боловсруулж, сурталчилна	НСГ
61.		Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын бэлтгэл ажлыг хангах, туршилтын тооллогыг явуулна	
Улаанбаатар хотоос гадаад орны хотуудтай тогтоосон ах дүүгийн, найрамдалт болон энгийн харилцааг өргөжүүлж, нийслэлийн гадаад харилцааг эдийн засгийн агуулгатай хөгжүүлэх зорилт дэвшүүлж ажиллана.			

62.	5.17	Ах дүү харилцаат хотууд болон харилцаат хотуудын дүүрэг, үйлдвэр аж ахуйн нэгжүүдтэй бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөл боломжоор хангана	ГХХАХ
63.		Донор байгууллагуудтай хамтын ажиллагааны төлөвлөгөө байгуулж ажиллана	
64.		Улаанбаатар хотын хөгжлийн асуудалтай холбоотой төсөл хэрэгжүүлэгч олон улсын байгууллагуудын уулзалтыг зохион байгуулна	
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын техник технологийг шинэчилж, ажилтнуудын чадавхийг бэхжүүлж, хяналтын үр нөлөөг сайжруулна.			
65.	5.18	Үйлдвэрлэл, үйлчилгээний зарим стандарт, норм нормативт өөрчлөлт оруулах санал боловсруулна	НМХГ
66.		Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудад санхүүгийн давтамжит болон түүвэрчилсэн шалгалт хийнэ	
67.		Хүнсний аюулгүй байдлын хяналт, задлан шинжилгээний лаборатори байгуулж, хяналтын мэргэшсэн ажилтны нөөц бүрдүүлнэ	
68.		Улсын комиссын шийдвэргүй үйл ажиллагаа явуулж буй барилгын ашиглалтын асуудлыг шийдвэрлэнэ	НМХГ, УСУГ, УБЦТС, УБДС
69.		Орчны эрүүл ахуйн чиглэлээр хяналт шинжилгээ хийхэд шаардлагатай рН метр, биологийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох багажаар улсын байцаагчдыг хангана	НМХГ
70.		Барилга байгууламжийн хийц бүтээцийн чанар тодорхойлох багаж төхөөрөмжтэй болно	